МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
**ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 30 өдөр Дугаар А/360 Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Сайнцагаан сумын 8-р багийн нутаг дэвсгэрт байрлах Мод үржүүлгийн талбайн модны усалгааны системд зориулан 1,7км-ийн 6кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0,4кВ-н, 160кВа дэд станц, 0,4кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Ж.Мөнхчулуун | (Аймгийн Засаг даргын орлогч) |
| Нарийн бичгийн дарга: | О.Мөнхзул | (Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн мэргэжилтэн) |
| Гишүүд: | Б.Золжаргал | (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч) |
| | Н.Эрдэнэбат | (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Б.Доржхорол | (Аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн) |
| | Т.Сайнжаргал | ("МОНЦАХЭР" ХХК-ийн инженер) |
| | З.Одончимэг | ("Ногоон Ази Сүлжээ" ТББ-ын мэргэжилтэн) |
| | Г.Ач-Эрдэнэ | ("Цогц Уран" ХХК-ийн инженер) |
| | Д.Батхалх | ("Мандах дүүрэн" ХХК-ийн ерөнхий инженер) |
| | С.Энхбат | (БЗӨБ ТӨХК-ний Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер) |
| | Ч.Оюунсайхан | (Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн Архивын сан хөмрөгч) |

Хоёр. Угсралтын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Ж.Мөнхчулуун)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

438010322